



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020

Э-сонин

11-Р САР

88-р дугаар






Зах зээлийн тойм


/2020.11.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	19
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	1,939,212,967
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	1,853,046,446
Багцын арилжаа	522,316,010
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	57,266,521
Компанийн бонд /хоёрдогч/	28,900,000
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	17,723,094
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	17,189,058
Багцын арилжаа	7,913,138
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	533,751
Компанийн бонд /хоёрдогч/	285
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	47,243


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	194
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	167
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.11.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	АРД СЕКЮРИТИЗ ХХК	7,991,506	1,184,564,273	1,322,138	547,366,246	1,813,505,565
2	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	190,002	35,060,463	2,484,810	307,078,608	342,139,071
3	БУМБАТ-АЛТАЙ ХХК	195,694	44,049,843	6,349,524	288,044,476	337,317,045
4	БИДИСЕК ХК	537,631	102,801,292	1,436,099	208,868,485	312,054,776
5	ГҮҮДСЕК ХХК	6,196,526	273,908,996	28,068	3,292,982	277,201,978
6	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	421,640	34,878,459	3,055,406	226,617,124	264,048,737
7	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	300,216	41,080,551	718,171	63,861,882	106,552,262
8	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	388,356	35,927,808	377,685	45,967,027	82,389,352
9	АРД КАПИТАЛ ГРУПП ХХК	271,616	23,925,722	304,541	27,583,986	72,265,195
10	МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ХХК	188,776	5,656,418	319,523	24,147,870	67,054,288
11	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	128,625	10,192,083	57,825	29,033,665	39,225,748
12	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	726	2,108,689	1,847	5,261,963	28,109,382
13	МОНСЕК ХХК	175,657	13,850,001	123,050	12,126,847	27,091,348
14	ГАУЛИ ХХК	51,216	9,610,227	30,258	15,366,582	24,976,810
15	НЭЙШНЛ СЭКЮРИТИС ХХК	60,975	12,213,770	3,000	6,919,800	19,186,658
16	ЦЕНТРАЛ СЕКЬЮРИТИЙЗ ҮЦК	4,925	684,912	92,142	9,354,030	10,038,941
17	ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ХХК	10,708	1,458,373	96,352	6,990,770	8,925,109
18	БЛҮМСБЮРИ СЕКЬЮРИТИЕС ХХК	579	421,900	112,705	7,550,108	7,972,008
19	ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ХХК	2,875	3,738,725	630	4,005,500	7,744,225
20	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	0	0	239,908	7,203,442	7,203,442

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.11.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт %/
1	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	10,906,760	501,724,171	50.99	42.54	10.70
2	TUM	ТҮМЭН ШУВУУТ	2,051,749	300,706,119	164.98	150.00	1.74
3	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1,291,266	37,082,131	30.90	27.00	-2.82
4	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	599,135	39,630,601	70.95	64.00	6.34
5	ХОС	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	533,751	57,266,522	114.00	103.00	-6.03
6	NEH	ДАРХАН НЭХИЙ	520,379	7,602,695	14.98	14.05	0.00
7	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	374,411	242,110,964	680.00	590.00	0.33
8	AIC	АРД ДААТГАЛ ХК	310,623	226,172,724	760.00	690.00	0.62
9	APU	АПУ	263,341	152,480,570	599.00	566.00	1.76
10	HGN	ХӨХ ГАН	108,752	6,332,690	85.00	55.00	-26.75
11	MFC	МОНОС ХҮНС	105,224	6,994,872	68.39	64.00	-0.51
12	SUU	СҮҮ	94,548	19,618,459	210.00	202.03	-0.17
13	GOV	ГОВЬ	94,006	18,136,565	200.00	186.00	-3.20
14	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	92,817	9,687,530	104.47	103.99	-0.09
15	ITLS	АЙТҮҮЛС	70,111	5,269,672	79.00	72.00	1.57
16	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	62,956	87,056,623	1,440.00	1,330.00	3.78
17	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН ХК	53,195	45,427,211	884.00	844.00	-0.10
18	BODI	БОДЬ ДААТГАЛ	35,954	4,736,900	158.00	121.00	15.34
19	RMC	РЕМИКОН	30,707	770,599	25.50	23.51	7.77
20	MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	22,469	4,173,642	194.50	180.00	2.19



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.11.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-11-01	2020-11-30		
1	МЕРЕКС	19,320	19	29.00	10.00	52.63
2	МОНГОЛ АЛТ	2	5500	7,270.00	1,770.00	32.18
3	БОДЬ ДААТГАЛ	35,954	114.44	132.00	17.56	15.34
4	ШИНЭСТ	87	100	115.00	15.00	15.00
5	УВС ЧАЦАРГАНА	1	290	333.50	43.50	15.00
6	ТЭЭВЭР ДАРХАН	1	8595	9,880.00	1,285.00	14.95
7	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	3,534	16.1	18.50	2.40	14.91
8	ЖЕНКО ТУР БЮРО	7,762	73.5	84.00	10.50	14.29
9	ТҮШИГ УУЛ	860	720	820.00	100.00	13.89
10	ТАЛХ ЧИХЭР	79	16000	18,000.00	2,000.00	12.50
11	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	17	400	450.00	50.00	12.50
12	МАНДАЛ ДААТГАЛ	10,906,760	43.91	48.61	4.70	10.70
13	АРИГ ГАЛ	34	2545	2,800.00	255.00	10.02
14	РЕМИКОН	30,707	23.54	25.37	1.83	7.77
15	ТАВАН ТОЛГОЙ	4,180	5790	6,175.00	385.00	6.65
16	АРД КРЕДИТ ББСБ ХК	599,135	63.1	67.10	4.00	6.34
17	ЭРДЭНЭТ ХҮНС	25	3200	3,400.00	200.00	6.25
18	БӨХӨГ	6,041	1417	1,500.00	83.00	5.86
19	ЭРДЭНЭС СОЛЮШИНС	1	420	440.00	20.00	4.76
20	ХИШИГ УУЛ	1	450	470.00	85.00	4.44

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.11.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-11-01	2020-11-30		
1	ХӨХ ГАН	108,752	75.1	55.01	-20.09	-26.75
2	УЛААНБААТАР ХИВС	14	21100	17,000.00	-4,100.00	-19.43
3	МОНГОЛЫН ХӨГЖИЛ	13	3700	3,100.00	-600.00	-16.22
4	ТЕХНИК ИМПОРТ	475	8055	6,900.00	-1,155.00	-14.34
5	ШАРЫН ГОЛ	331	900	778.20	-121.80	-13.53
6	МҮДИКС	1	7800	6,900.00	-900.00	-11.54
7	АТАР-ӨРГӨӨ	5	73000	65,000.00	-8,000.00	-10.96
8	МОНИНЖБАР	13,094	89.8	80.00	-9.80	-10.91
9	НАКО ТҮЛШ	1,551	28	25.00	-3.00	-10.71
10	БИ ДИ СЕК	2,205	862	791.50	-70.50	-8.18
11	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	30	1900	1,750.00	-150.00	-7.89
12	ДОРНОД ХУДАЛДАА	1	21980	20,500.00	-1,480.00	-6.73
13	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН	533,751	111.87	105.12	-6.75	-6.03
14	ХАНЫН МАТЕРИАЛ	3	1880	1,800.00	-80.00	-4.26
15	ХАР ТАРВАГАТАЙ	160	4945	4,766.00	-179.00	-3.62



"БИД ИРЭЭДҮЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД" ТЭМЦЭЭН ЭХЭЛЖЭЭ



Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан "Бид ирээдүйн хөрөнгө оруулагчид" тэмцээнийг үндэсний томоохон их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулахаар боллоо.

Энэхүү тэмцээний зорилго нь санхүүгийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын хөрөнгийн зах зээлийн талаарх онолын мэдлэгээ бататган, цааш гүнзгийрүүлэн судлах нөхцөлийг бүрдүүлэн практик дадлага олж авах, харилцан туршлага солилцож багаар ажиллах чадварыг дээшлүүлэн ирээдүйн мэргэшсэн чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд чиглэж байна.

Тэмцээнд оролцогчид хөрөнгө оруулалтын багц үүсгэн арилжаанд бодит мөнгөөр оролцохоороо онцлог бөгөөд МУИС, ШУТИС, СЭЗИС, ХААИС, ХУИС-иудын 5 баг, нийт 25 оюутан мэдлэг ур чадвараа сорин өрсөлдөж байна.



"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ЭЭС III УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Эрдэнэ РесурсДевелопмент Корпораци нь III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан болон Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн талаар мэдээллээ. Тайлант хугацаанд хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлсэнтэй холбоотойгоор 3.5 сая долларын хайгуулын зардал гаргасан бөгөөд цаашид Хар морь талбайн хайгуулын ажлын II шатыг эхлүүлээд байна.

Үйл явдал

Компани 2020 оны 8-р сард татан төвлөрүүлсэн 20 сая кан.долларын хөрөнгө оруулалт болон Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурснаар хөгжүүлэлтэд шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломж нэмэгдэж байна.

ЭРДЭНЭ РЕСУРС КАНАДЫН ЭКСПОРТ ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГТАЙ САНХҮҮЖИЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЖЭЭ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Канадын Экспорт хөгжлийн агентлаг ("EDC")-тай Монгол Улсын баруун өмнөд бүсэд орших Баян Хөндий алтны төслийн хөгжүүлэлтийн хүрээнд 55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичиг ("Mandate letter")-г гарын үсэг зурлаа.

Канадын экспорт хөгжлийн агентлаг (EDC) нь Канад Улсын компаниудыг дэлхий дахинд амжилттай үйл ажиллагаа эрхлэхэд тусламж үзүүлэхэд чиглэдэг төрийн өмчит санхүүгийн корпораци юм.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "EDC-тэй хамтран баталгаажуулсан зээлийн санхүүжилтийн баримт бичиг нь Баян Хөндий алтны төслийн хөгжилд нэгэн чухал ахиц боллоо. EDC нь Монгол болон олон улсад уул уурхайн төслүүдийг дэмжсээр ирсэн байгууллага. EDC болон манай томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартыг хамгийн өндөр түвшинд байлгаж, Монголын болон олон улсын нийт оролцогч талуудын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж хэллээ.

АНХНЫ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС БҮРТГЭГДЖЭЭ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 938 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/75 тоот тушаалаар "Инвекор актив ТЗК" ХХК-ийн гаргаж буй доорх нөхцөлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ.

Үнэт цаасны нэр: Инвекор актив ХБҮЦ

Үнэт цаасны тоо ширхэг: 10,000 ширхэг

Үнэт цаасны нэрлэсэн үнэ: 400,000 төгрөг

Үнэт цаасны нийт үнийн дүн: 4,000,000,000 төгрөг

Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь

хэмжээ: Жилийн 16.4%

Үнэт цаасны хугацаа: 24 сар

Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа /давтамж/: 3 сар тутамд

Ийнхүү, Монголын хөрөнгийн хөрөнгийн зах зээлд дахин нэгэн шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтэрч, хөрөнгө оруулагчид тогтмол хүү төлдөг, хадгаламжийн дундаж хүүгийн хэмжээнээс өндөр бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах боломж нээгдлээ.



"ТҮМЭН ШУВУУТ" ХК ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ҮЙЛЧЛЭХ-IR ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас хөрөнгийн зах зээл үүссэний 30 жилийн ойг тохиолдуулан бүртгэлтэй компаниудын засаглалыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангуулахаар анхаарч ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос хувьцаат компаниудад хандан гаргасан ил тод, ёс зүйтэй ажиллах уриалгыг дэмжин “Түмэн шувуут” ХК нь “Хөрөнгө оруулагчдад үйлчлэх IR” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа тухай олон нийтэд танилцуулах хэвлэлийн бага хурлыг Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд СЗХ-ны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар нар оролцсон юм.


“Хөрөнгө оруулагчдад үйлчлэх IR” хөтөлбөрийг дэлхийн олон улс орны нээлттэй компаниуд хэрэгжүүлдэг бөгөөд хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажилласнаар хөрөнгө оруулагчидтай бат бэх харилцаа холбоо, итгэлцлийг үүсгэх, урт хугацааны хөрөнгө оруулагчидтай болох, компанийн үнэ цэнийг тогтвортой хадгалах, нэмэлт санхүүжилт татах үйл явцыг хялбаршуулах зэрэг олон талын ач холбогдлыг бий болгодог байна.

“СҮҮ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА ӨӨРЧЛӨГДСӨН БАЙНА

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 14 тоот тогтоолоор тус компанийн Гүйцэтгэх захирал Мэндбаяр овогтой Мандхайг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн албан тушаалаас нь чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчээр Доржготов овогтой Эрдэнэчимэгийг томилсон байна.

Үйл явдал

“ТҮМЭН ШУВУУТ” ХК ХУВЬЦААТАЙ ӨНДӨГ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ



“Түмэн шувуут” ХК хэрэглэгчиддээ зориулж “Хувьцаатай өндөг” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээ өнөөдөр олон нийтэд зарлалаа.

Уг хөтөлбөрт “Сувиллын өндөг” нэрийн бүтээгдэхүүнийг худалдан авсан хүн бүр хамрагдах боломжтой. Худалдан авагч E-CODE аппликейшн татаж ашигласнаар өндөг бүрт 5₮-ийн үнэ цэнэ (egg point) хуримтлагдаж, хуримтлалын дүнтэй дүйцэх “Түмэн шувуут” ХК-ийн хувьцаа олгогдох юм.





ХУГАЦААТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН 42 ХК– ИЙН АНХААРАЛД

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23.11 дэх заалтанд үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, Биржээс тогтоосон шалгуур, шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр, хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй, үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй зэрэг болон хууль журамд заасан бусад үндэслэлээр үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна гэж тусгасан байдаг.

Дээрх журмын дагуу үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа нийт 42 компанид 2020 оны 12 сарын 01-ний дотор журмаар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ирүүлэх талаар хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн билээ.

Энэхүү заасан хугацаанд МХБ-д хариу ирүүлээгүй, холбогдох зөрчлийг арилгаагүй компаниудыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авах тул холбогдох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, журмын шалгуур, шаардлагыг хангаж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн зүгээс тус компаниудад дахин анхааруулж байна.

№	Симбол	Компанийн нэр
1	ARH	"Сэлэнгэ Ар хөвч" ХК
2	ATI	"Агротехимпекс" ХК
3	ALA	"Алтай нэгдэл" ХК
4	CND	"АСБИ" ХК
5	MDZ	"Монгол дизель" ХК
6	NUR	"Нийслэл өргөө" ХК
7	SES	"Сэлэнгэ-сүрэг" ХК
8	IND	"Эрдэнэт-Зандан" ХК
9	ORD	"Орхондалай" ХК
10	TSA	"Цагаантолгой" ХК
11	SIL	"Силикат" ХК
12	BHR	"Бинсэ" ХК
13	AAR	"Автозам" ХК
14	HMK	"Ханын материал" ХК
15	BBD	"Стандарт проперти групп" ХК
16	BOR	"Борнуур" ХК
17	ALD	"Азык" ХК
18	JGL	"Говийн өндөр" ХК
19	DMA	"Дэвшил мандал" ХК
20	INT	"Ингэттолгой" ХК
21	KEK	"Монгол керамик" ХК
22	ACL	"Тээвэр-Ачлал" ХК
23	TVT	"Хар тарвагатай" ХК
24	TAS	"Эрдэнэт хүнс" ХК
25	ECV	"Эрэнцав" ХК

Үйл явдал

26	EAZ	"Эрдэнэт авто зам" ХК
27	BAZ	"Люкс занаду групп" ХК
28	DRN	"Дорнод" ХК
29	ULZ	"Өлзий-Дундговь" ХК
30	HUT	"Хөдөөгийн тээвэр" ХК
31	HAH	"Хүнс-Архангай" ХК
32	SIM	"Шим" ХК
33	BTL	"Баянталбай" ХК
34	HML	"Глобал монголиа холдингс" ХК
35	GNR	"Гонир" ХК
36	DAO	"Хуртай" ХК
37	TGS	"Номин хишиг" ХК
38	UNS	"Улаансан" ХК
39	DRU	"Дөрвөн Уул" ХК
40	DIM	"Дорнод импекс" ХК
41	MUDX	"МҮДИКС" ХК
42	HRL	"Хэрлэн хивс" ХК

"МОНОС ХҮНС" ХК ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 8.58 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Монос Хүнс" ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх зарцуулалтын тайланг ирүүллээ. Тус тайланд дурдсанаар нийт 8.02 тэрбум төгрөгийг доорх байдлаар зарцуулсан байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн барилгын өргөтгөл -2.4 тэрбум төгрөг;
- Тоног төхөөрөмж, тээвэр хэрэсэл, тавилга -4.3 тэрбум төгрөг;
- Эргэлтийн хөрөнгө - 874.1 сая төгрөг;
- Шинэ технологид хөрөнгө оруулах - 365.1 сая төгрөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА ОНЛАЙН ГОРИМООР ХЭВИЙН ЯВАГДАНА

Монгол Улсын Засгийн газар Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу Монгол Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих шийдвэрийг гаргасантай холбогдуулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2020 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд зайнаас ажиллах горимд шилжих бөгөөд энэ өдрүүдэд үнэт цаасны арилжаа онлайн горимоор хэвийн явагдана.

АЛБАН БИЧГИЙГ ЦАХИМААР АВАХ ТУХАЙ

Ковид-19 цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд албан байгууллагууд болон иргэдээс "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн бичиг хэрэгт ирүүлэх албан тоот, захидлуудыг doc@mse.mn цахим хаягаар хүлээн авч байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN